



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 421

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн  
төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдийг  
чөлөөлөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй хавсралтад заасан гишүүдийг 2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

000550

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2020 оны 09 дүгээр сарын 08-ны  
өдрийн 42/ дүгээр тогтоолын хавсралт



ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛӨӨС ЧӨЛӨӨЛӨГДӨХ ГИШҮҮДИЙН НЭРС

Д/д	Хуулийн этгээдийн нэрс	Чөлөөлөгдөх гишүүд
1	“Дархан АЗЗА” ТӨХК, “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК	Т.Хулан /ТӨБЗГ-ын Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтсийн мэргэжилтэн/
2	“Төв АЗЗА” ТӨХК, “Эрдэнэсант АЗЗА” ТӨХК	А.Цээнэ /ТӨБЗГ-ын Хууль, эрх зүйн албаны хуулийн мэргэжилтэн/
3	“Ховд АЗЗА” ТӨХК, “Увс АЗЗА” ТӨХК, “Завхан АЗЗА” ТӨХК, “Говь-Алтай АЗЗА” ТӨХК	А.Дагвадорж /ТӨБЗГ-ын Дэд дарга/
4	“Булган АЗЗА” ТӨХК, “Орхон АЗЗА” ТӨХК, “Хөвсгөл АЗЗА” ТӨХК	О.Мөнхсоёл /ТӨБЗГ-ын Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн/
5	“Өвөрхангай АЗЗА” ТӨХК, “Архангай АЗЗА” ТӨХК, “Хархорин АЗЗА” ТӨХК	Ж.Баттулга /ТӨБЗГ-ын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн/, Э.Лувсандагва / ТӨБЗГ-ын нярав/